

# БАНКНЫ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

---

2018 ОНЫ III УЛИРЛЫН  
ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ТАЙЛАН



2018 оны 9 дүгээр сар



## 1 СУДАЛГААНЫ ҮР ДҮН

### Зээлийн шалгуур

- Банкууд өнгөрсөн 3 сарын хугацаанд ААН болон өрхүүдэд олгох зээлийн шалгуурт төдийлөн өөрчлөлт оруулаагүй бөгөөд ирэх 3 сарын хугацаанд ч зээлийн шалгуурыг өөрчлөх төлөвгүй байна.

### Зээлийн нөхцөл

- Өнгөрсөн 3 сарын хугацаанд ААН болон өрхүүдэд олгох зээлийн хүүгээ бууруулсан бол ирэх 3 сарын хугацаанд зээлийн нөхцөлөө өөрчлөх хандлагагүй байна.

### Зээлийн эрэлт

- Өнгөрсөн 3 сарын хугацаанд ААН-ийн зээлийн эрэлт (*тэр дундаа худалдаа, үйлчилгээний салбарт олгож буй*) бага зэрэг нэмэгдсэн бол өрхийн зээлийн эрэлт нэлээд хэмжээгээр өссөн байна;
- Ирэх 3 сарын хугацаанд банкуудын хувьд ААН болон өрхийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэнэ гэсэн хүлээлт давамгайлж байна.

Хүснэгт 1: Судалгааны нэгдсэн үр дүн

Банкууд / зээлийн төлөв	Зээлийн шалгуур		Зээлийн нөхцөл		Зээлийн эрэлт	
	ААН	Өрхийн	ААН	Өрхийн	ААН	Өрхийн
Өнгөрсөн 3 сарын хугацаанд						
Том	0	0	↓	0	↑	↑
Дунд	0	0	0	0	↑	0
Жижиг	0	0	0	↓	↑	↑↑
Ирэх 3 сарын хугацаанд						
Том	0	0	0	0	0	0
Дунд	0	0	0	0	↑	0
Жижиг	0	0	0	0	0	↑

Тэмдэглэл : ↑ бага зэрэг чангарсан , ↓ бага зэрэг суларсан, ↑ бага зэрэг нэмэгдэх, ↓ бага зэрэг буурах, ↑↑ нэлээд нэмэгдэх, 0 өөрчлөгдөөгүй




## 2 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### Судалгааны ажлын зорилго

Энэхүү судалгааны зорилго нь Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж буй арилжааны банкуудын зээлийн үйл ажиллагаа, шалгуур, түүний нөхцөл болон ирээдүйн төлөвийг тодорхойлж, бодлогын шийдвэр гаргалтанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

### Судалгааны хамрах хүрээ, хугацаа

Зураг 1: Банкуудын зээлийн хэмжээ



- Банкны зээлийн төлөвийн судалгааг 2018 оны III улиралд Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж буй нийт 14 банкуудын дунд гүйцэтгэв.
- Энэхүү судалгааг гүйцэтгэхдээ тухайн банкны зээлийн үйл ажиллагаа хариуцсан, шийдвэр гаргах түвшний удирдах албан тушаалтнуудаас асуулга авсан болно.
- Судалгаанд оролцсон банкуудын 2018 оны 7 дугаар сарын байдлаарх зээлийн үлдэгдлийг Зураг 1-т харьцуулан харуулав.

### Арга зүйн товч тайлбар

Банкны зээлийн төлөвийн судалгаа нь (i) Зээлийн шалгуур<sup>1</sup>, (ii) Зээлийн нөхцөл<sup>2</sup> болон (iii) Зээлийн эрэлт гэсэн үндсэн гурван бүлэг асуултуудаас бүрдэнэ.

Хүснэгт 2: Индексийн тооцоолол

Индексийн утга	-1.0	-0.5	0	0.5	1.0
Зээлийн шалгуур	Нэлээд суларсан	Бага зэрэг суларсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг чангарсан	Нэлээд чангарсан
Зээлийн нөхцөл	Нэлээд суларсан	Бага зэрэг суларсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг чангарсан	Нэлээд чангарсан
Зээлийн эрэлт	Нэлээд багассан	Бага зэрэг багассан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг нэмэгдсэн	Нэлээд нэмэгдсэн

Судалгааны үр дүнг нэгтгэхдээ банкуудын чанарын хариултуудыг нэг утгатайгаар тодорхойлохын тулд тоон утга руу хөрвүүлсэн. Ингэхдээ [-1; +1] хоорондох утгуудад чанарын асуултуудыг Хүснэгт 2-д өгөгдсөн байдлаар индекст хөрвүүлсэн.

<sup>1</sup> Зээлийн шалгуур (Credit standards) Зээлдэгчийг зээлийн шаардлага хангах эсэхийг тодорхойлдог банкны дотоод журам, аргачлал, процедур. Тухайлбал, зээлдэгчийн өр-орлогын харьцааг тооцож, тодорхой хязгаар заах.

<sup>2</sup> Зээлийн нөхцөл (Credit terms and conditions) Зээлдүүлэгч болон зээлдэгчийн харилцан тохиролцсон зээлийн дүн, хугацаа, хүү болон бусад нөхцөлийг ойлгоно (Нэр томъёоны тайлбар толиос).



Нийт системийн зээлийн төлөвийг тодорхойлохдоо банк тус бүрийн зээлийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээг тухайн банкны харгалзах индексээр үржүүлэх замаар жигнэсэн дундаж утгыг тооцон ашигласан.

### 3 СУДАЛГААНЫ ҮР ДҮН

#### 3.1 Зээлийн шалгуур

ААН-ийн зээлийн шалгуурын ерөнхий индексийг цаг хугацааны хувьд авч үзвэл өнгөрсөн 3 сарын индекс 2016 оны эхнээс тогтмол буурч, энэ улиралд -0.16 гэсэн утгад хүрсэн нь банкуудын хувьд зээлийн шалгуур үзүүлэлтээ аажмаар сулруулах хандлага давамгайлж байсныг илтгэнэ. Харин банкуудын зээлийн төлөвийн 2018 оны III улирлын судалгааны үр дүнгээс харахад өнгөрсөн 3 сарын хугацаанд банкууд зээлийн шалгууртаа төдийлөн өөрчлөлт оруулаагүй байна. Мөн ирэх 3 сарын хугацаан дахь зээлийн шалгууртаа өөрчлөлт оруулах хандлага ажиглагдахгүй байна /Зураг 2/.

Зураг 2: ААН-д олгох зээлийн шалгуур



Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа 2018.III, Монголбанк


Ийнхүү банкууд зээлийн шалгуур үзүүлэлтээ хэвэнд нь хадгалахад эдийн засгийн өнөөдрийн нөхцөл байдал сэргэж байгаа үе голлон нөлөөлжээ.

Өрхүүдэд олгох зээлийн шалгуурын ерөнхий индексийг авч үзвэл 2018 оны эхний хоёр улиралд зээлийн шалгуураа бага зэрэг сулруулсан бол 2018 оны III улиралд зээлийн шалгууртаа өөрчлөлт оруулаагүй гэсэн үр дүн гарлаа. Мөн ирэх 3 сард өрхийн зээлийн шалгуураа өөрчлөх төлөвгүй байна /Зураг 3/.

Ийнхүү банкууд өрхүүдэд олгох зээлийн шалгуур үзүүлэлтээ хэвээр хадгалахад эдийн засгийн таатай нөхцөл болон эх үүсвэрийн өртөг буурсан зэрэг нь голлон нөлөөлжээ.



**Зураг 3: Өрхүүдэд олгох зээлийн шалгуур**





Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа 2018.III, Монголбанк

### 3.2 Зээлийн нөхцөл

Банкууд өнгөрсөн 3 сарын хугацаанд ААН болон өрхүүдэд олгох зээлийн хүүг бага зэрэг бууруулж зээлийн нөхцөлөө ялимгүй сулруулсан байна. Ирэх 3 сарын хугацаанд өрхүүдэд олгох зээлийн хугацааг бага зэрэг сунгах төлөвтэй байгаа бол зээлийн бусад нөхцөлийг төдийлөн өөрчлөхгүй гэж хариулжээ /Зураг 4,5/. Харин ААН-уудад олгох зээлийн нөхцөлийг өөрчлөх төлөвгүй байна.

**Зураг 4: ААН-д олгох зээлийн нөхцөл**

**Зураг 5: Өрхүүдэд олгох зээлийн нөхцөл**




Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа 2018.III, Монголбанк



### 3.3 Зээлийн эрэлт

Өнгөрсөн 3 сарын хугацаанд ААН-ийн зээлийн эрэлт (*тэр дундаа худалдаа, үйлчилгээний салбар*) өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад нэмэгдсэн байна. Ирэх 3 сарын хугацаанд зээлийн эрэлт нэмэгдэнэ гэсэн хүлээлт өмнөх улирлын судалгааны үр дүнтэй харьцуулахад бага зэрэг буурсан хэдий ч зээлийн эрэлт бага зэрэг өснө гэсэн хүлээлт хадгалагдаж байна. Ялангуяа боловсруулах болон худалдаа, үйлчилгээний салбарын зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэнэ гэж хариулсан бол барилгын салбарт олгох зээлийн эрэлт бага зэрэг буурна гэсэн хүлээлттэй байна.


**Зураг 6: ААН-ийн зээлийн эрэлтийн төлөв, салбараар**



Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа 2018.III, Монголбанк

Өнгөрсөн 3 сарын хугацаанд өрхийн зээлийн эрэлт (*тэр дундаа цалин, тэтгэвэр, хэрэглээний зээл*) мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн гэж банкууд үзэж байна. Судалгааны үр дүнгээр өрхийн зээлийн эрэлт сүүлийн 3 судалгаагаар өндөр байна. Мөн банкууд ирэх 3 сард өрхийн зээлийн эрэлт бага зэрэг өснө гэсэн хүлээлттэй байна.

**Зураг 7: Өрхийн зээлийн эрэлтийн төлөв, зориулалтаар**



Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа 2018.III, Монголбанк